

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Энэхүү тайлан нь Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй компаниудын байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын чиглэлээр тайлант хугацаанд авч хэрэгжүүлсэн стратеги, арга хэмжээ, нөхцөл байдлыг хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчид, олон нийтэд ил тод нээлттэй тайлагнах зорилготой.

Хэсэг 1, 2, 3 нь нийт үнэт цаас гаргагч компаниудад хамааралтай бөгөөд Хэсэг 4 нь зөвхөн тухайн салбарт үйл ажиллагаа явуулж буй үнэт цаас гаргагчдад хамаарна.

Хэрэв тайлангийн маягтад заасан аливаа мэдээллийг цуглуулах, тайлагнах боломжгүй бол тайлагнах боломжтой талаарх тайлбар, цаашид мэдээллийг тайлагнах чиглэлд авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар 'тайлбар' хэсэгт бичнэ үү.

Огноо (он, сар, өдөр):	2025.04.28
Үнэт цаас гаргагчийн нэр:	"ХААН Банк" ХК
Үнэт цаасны нэр, код (МХБ симбол):	KHAN
Салбарын ангилал:	Санхүү
Тайланд орсон компаниуд (энэхүү тайланд орсон толгой болон охин компаниудын мэдээлэл):	"ХААН Банк" ХК
Тайлангийн хамрах хугацаа:	2024.01.01-2024.12.31
Хариуцсан албан тушаалтны овог нэр, албан тушаал, холбоо барих имэйл хаяг, утас:	М.Мандахмягмар, Тогтвортой хөгжлийн газрын захирал, sustainability@khanbank.com
Тайланг баталгаажуулсан гүйцэтгэх удирдлагын мэдээлэл (нэр, албан тушаал):	Ю.Төрмөнх, Стратеги хариуцсан дэд захирал
Гүйцэтгэх удирдлага эсвэл ТУЗ-ийн даргын гарын үсэг:	

Код	Бүлэг	Шалгуур үзүүлэлт	Үзүүлэлт (өмнөх он)	Үзүүлэлт (тайлант он)	Хэмжих нэгж	Нэмэлт мэдээлэл
Тогтвортой хөгжлийн удирдлагын системийн дотоод шалгуур үзүүлэлтүүд						
MS1.1	Тогтвортой хөгжлийн удирдлагын амлалт	Удирдлагын амлалт	Удирдлагаас баталсан тогтвортой хөгжлийн амлалт/мэдэгдэл байдаг эсэх	Тийм	Тийм	ХААН Банкны удирдлагаас албан ёсоор дагаж мөрдөхөө илэрхийлсэн дотоодын болон олон улсын баримт бичгүүд: 1. 2010 онд НҮБ-ын Даян дэлхийн гэрээний 4 бүлэгт 10 зарчим 2. 2013 онд МУ-ын Тогтвортой санхүүжилтийн хөтөлбөрийн 8 зарчим 3. 2017 онд "Нэг бүс-нэг зам" санаачлагын дэргэдэх Ногоон хөрөнгө оруулалтын 7 зарчим 4. 2023 он НҮБ-ын Хүүхдийн сангийн "Бизнес ба хүүхдийн эрх" 10 зарчим Эдгээрээс гадна Монгол Улсын Тогтвортой санхүүгийн үндэсний замын зургийн зорилтыг ханган ажиллахад анхаарч 2025 он гэхэд банкныхаа нийт эзэлийн багцын 10 хувийг ногоон эзэлийн багцаар бүрдүүлэх зорилт тавин, Тогтвортой хөгжлийн бодлогынхоо хүрээнд зорилтот ажлуудыг хэрэгжүүлэн ажилладаг.
MS2.1		Тогтвортой хөгжлийн бодлого, зохицуулалт	Тогтвортой хөгжлийн бодлого, зорилтуудыг тодорхойлж баталсан эсэх	Тийм	Тийм	https://www.khanbank.com/personal/about/sustainable-development-policy/
MS2.2		Танай компани тогтвортой хөгжлийн асуудал хариуцсан хороо байдаг эсэх	Танай компани тогтвортой хөгжлийн асуудал хариуцсан хороо байдаг эсэх	Тийм	Тийм	2024 онд Төв банкны дэргэдэх Тогтвортой хөгжлийн хороог байгуулан сар бүр Тогтвортой хөгжлийн чиглэлээрх асуудлыг хэлэлцэн хуралддаг.
MS3.1		ТУЗ-ийн түвшинд тогтвортой хөгжил / БОНЗ-ын асуудал хариуцсан гишүүн (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх	ТУЗ-ийн түвшинд тогтвортой хөгжил / БОНЗ-ын асуудал хариуцсан гишүүн (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх	Тийм	Тийм	Банкны ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, цалин урамшууллын хороонд банкны Тогтвортой хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хагас жил тутам тайлагнадаг.

MS3.2	Тогтвортой хөгжлийн удирдлагын систем	Бүтэц удирдлага	Гүйцэтгэх удирдлагын түвшинд тогтвортой хөгжил/ БОНЗ-ын асуудал хариуцсан албан тушаалтан (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх	Тийм	Тийм		ХААН Банкны Стратеги хариуцсан дэд захирал банкны Тогтвортой хөгжлийн асуудлыг хариуцан ажилладаг буюу Тогтвортой хөгжлийн газрыг шууд удирдлагаар ханган ажилладаг.
MS3.3			Үйл ажиллагааны түвшинд тогтвортой хөгжил/ БОНЗ-ын асуудал хариуцсан албан тушаалтан (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх	Тийм	Тийм		ХААН Банкны Тогтвортой хөгжлийн газар нь үйл ажиллагааны түвшинд банкны Тогтвортой хөгжил, БОНЗ-ын асуудлыг хариуцан ажилладаг.
MS3.4			Танай компани ТУЗ-ийн хурлын хөтөлбөрт тогтвортой хөгжлийн асуудлыг албан ёсоор тусгадаг үү?	Тийм	Тийм		
MS3.5		Тогтвортой байдлын нөлөөллийн үнэлгээ	Танай компани эдийн засаг, байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөлөөс хэрхэн зайлсхийх, бууруулах, арилгах, эерэг үр нөлөөг сайжруулах талаар тайлбарласан нөлөөллийн үнэлгээ эсвэл матриц байдаг эсэх	Тийм	Тийм		Тайлант хугацаанд ХААН Банк олон улсын байгууллагаас Тогтвортой хөгжил, БОНЗ-ын чиглэлээр зөвлөх үйлчилгээ авч, банкны оролцогч талуудын оролцоог хангасан нөлөөллийн болон давхар материаллаг асуудлын матрицаа тодорхойлсон. Дэлгэрэнгүйг ХААН Банкны Тогтвортой хөгжил ба БОНЗ-ын 2024 оны тайлангийн "Оролцогч талуудын оролцоо ба давхар материаллаг байдлын үнэлгээ" хэсгээс үзнэ үү.
MS4.1		Чадавх бүрдүүлэлт	Нэг ажилтанд ногдох тогтвортой хөгжлийн тухай сургалтын жилийн дундаж цаг, хүйсээр	41	127	минут	Тогтвортой хөгжлийн талаарх цахим сургалт зарцуулах хугацаа: 37 мин, танхимын сургалт 90 минут байна.
MS4.2		Хяналт	Тогтвортой байдлын асуудал нь аудитын хорооны үйл ажиллагаа, дотоод хяналтын чиг үүрэгт хамаардаг үү?	Тийм	Тийм		Дотоод аудит нь банкны засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын зохистой бөгөөд үр дүнтэй, үр ашигтай байдлыг баталгаажуулах чиг үүрэгтэй ажилладаг ба энэ хүрээнд банкны засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналт нь зорилго стратегидaa хүрэхэд нийцтэй бөгөөд дэмжиж байгаа эсэхийг баталгаажуулдаг. Мөн дотоод аудит нь дунд хугацааны стратеги төлөвлөгөөндөө банкны тогтвортой хөгжлийн бодлогод тусгасан зорилтуудыг агуулсан бөгөөд мэргэшсэн хүний нөөц бүрдүүлэх, стратегийн түнш болох зорилтын хүрээнд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн БОНЗ-ын зөвлөх болон бусад зэрэг цол бүхий аудиторуудыг бэлтгэн ажиллаж байна.
MS4.3		Тогтвортой байдлын тайлагнал	Танай компани тогтвортой байдал / хөгжлийн тайлан (жилийн тайланд нэгтгэдэг эсвэл тусдаа тайлан)-гаа жилд нэгээс доошгүй удаа тайлагнадаг үү?	Тийм	Тийм		https://www.khanbank.com/personal/about/sustainability-report/
MS5.1			Танай компани олон улсын уур амьсгалын эрсдэлийн стандартын дагуу тайлагнадаг үү?	Үгүй	Үгүй		
MS5.2			Тогтвортой хөгжлийн болон БОНЗ-ын мэдээллийг хөндлөнгийн байгууллагаар баталгаажуулдаг үү?	Үгүй	Үгүй		
MS5.3		Гишүүнчлэл, хамтын ажиллагаа	Танай компани тогтвортой хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын болон дотоодын холбоо, нэгдэлтэй нэгдэж хамтран ажилладаг үү?	Тийм	Тийм		1) НҮБ-ын Даян дэлхийн гэрээ (UN Global Compact) 2) Ногоон хөрөнгө оруулалтын зарчмууд (Green Investment Principles) 3) Монголын Тогтвортой санхүүгийн холбоо 4) МҮХАҮТ-ын дэргэдэх КНХ ба Тогтвортой хөгжлийн зөвлөл 5) Монгол дахь Америкийн худалдааны танхимын КНХ-ын хороо 6) НҮБ-ын Хүүхдийн сан 7) Нүүрстөрөгчийн Нягтлан Бодох Бүртгэлийн Санхүүгийн Түншлэл (PCAF) 8) Монголын Бэлчээр Ашиглагчдын Холбоо 9) Тогтвортой Ноос Ноолуурын Эвсэл (SFA) 10) НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (UNDP) 11) Олон Улсын Санхүүгийн Корпораци (IFC) 12) Ногоон уур амьсгалын түншлэлийн сан (GCPF) 13) Монголын ногоон санхүүгийн корпораци 14) Ногоон барилгын хүрээлэн ТББ 15) JIM PCAF 16) Sustainable Fitch

E1.1	Эрчим хүч	Нийт эрчим хүчний хэрэглээ	Эрчим хүчний нийт зарцуулалтын хэмжээ болон зардал	3,010	22,847	Мегаватт	Тайлант онд банкны хэмжээнд нийт 22,847 мВт.ц эрчим хүчийг ашигласан үзүүлэлттэй байна. Тайлбар: 2023 онд банкны төв оффисын хэмжээнд цахилгаан эрчим хүчний зарцуулалтын хэмжээг тайлагнасан бол тайлант онд хэмжилтийн аргачлалыг сайжруулан банкны хэмжээнд нийт эрчим хүчний зарцуулалтын хэмжээ болон зардлыг тайлагналаа.
E1.2		Цахилгаан	Цахилгааны нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр)	3,010	9,475	Мегаватт	Тайлант онд банкны хэмжээнд нийт 9,475 мВт.ц цахилгаан эрчим хүчийг ашигласан үзүүлэлттэй байна. Тайлбар: 2023 онд банкны төв оффисын хэмжээнд цахилгаан эрчим хүчний зарцуулалтын хэмжээг тайлагнасан бол тайлант онд хэмжилтийн аргачлалыг сайжруулан банкны хэмжээнд нийт цахилгаан эрчим хүчний зарцуулалтын хэмжээг тайлагналаа.
E1.3		Дулаан	Дулааны нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр)	11,861	381,808	Гкал	Тайлант онд нийт банкны хэмжээнд 381,808 Гкал дулааны эрчим хүчийг ашигласан үзүүлэлттэй байна. Тайлбар: 2023 онд банкны төв оффисын хэмжээнд дулааны эрчим хүчний зарцуулалтын хэмжээг тайлагнасан бол тайлант онд хэмжилтийн аргачлалыг сайжруулан банкны хэмжээнд нийт дулааны эрчим хүчний зарцуулалтын хэмжээг тайлагналаа.
E1.4		Түлш	Түлшний нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр)	600	294,424	Литр	Тайлант онд нийт банкны хэмжээнд 446 тн нүүрс халаах зорилгоор, 292,424 л түлш автомашинд ашигласан байна. Тайлбар: 2023 онд зөвхөн цахилгаан үүсгэх зорилгоор ашигласан түлшний хэмжээг тайлагнасан бол тайлант онд хэмжилтийн аргачлалыг сайжруулан банкны хэмжээнд халаах болох автомашинд ашигласан нийт түлшний хэмжээг тайлагналаа.
E1.5		Хүрэн эрчим хүч	СЭХ-ээс бусад эх үүсвэрээс авсан эрчим хүчний хэрэглээний хувь	99.77	99.3	%	Тайлант онд нийт эрчим хүчний хэрэглээний 99.3 хувийг СЭХ-ээс бусад эх үүсвэрээс авсан үзүүлэлттэй байна.
E1.6		Сэргээгдэх эрчим хүч	СЭХ үүсвэрээс гаргаж авсан эрчим хүчний хэрэглээний хувь	0.23	0.7	%	Тайлант онд нийт эрчим хүчний хэрэглээний 0.7 хувийг СЭХ-ний эх үүсвэрээс авсан үзүүлэлттэй байна.
E2.1	Хүлэмжийн хийн ялгарал	3.1 Хүлэмжийн хийн ялгаруулалт	Компанийн шууд ба шууд бус үйл ажиллагаанаас ялгарсан нийт хүлэмжийн хийн дүн	-	-	CO2/тонн	
E2.2		3.2 Бууруулсан хүлэмжийн хий	Байгууллагын шууд ба шууд бус үйл ажиллагаанаас ялгарсан хүлэмжийн хийн нийт дүн (жилээр)	-	-	CO2/тонн	
E2.3		3.3 Дүйцүүлэх арга хэмжээ /Карбон офсет/	Нийт карбон офсет буюу дүйцүүлэх арга хэмжээний (мод тарих хөтөлбөр, эсвэл хүлэмжийн хийг бууруулах гадны төслийг дэмжих гэх мэт) бууралт	233.8	616	CO2/тонн	ХААН Банк сан 2021 оноос Улаанбаатар хотын дундуур урсах Сэлбэ голын эх, Их баяны ам орчимд нөхөн сэргээлт хийх шаардлагатай 40 га газрыг ойжуулах ажлыг эхлүүлсэн. 2024 онд нийт 27,900 гаруй модыг тарьсан байна.
E3.1	Уур амьсгалын өөрчлөлт	Уур амьсгалын бодлого, журам	Танай компани уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг тусдаа эсвэл бусад журамд тусгасан бодлоготой юу?	Тийм	Тийм		ХААН Банк Тогтвортой хөгжлийн бодлогоо 2023 онд шинэчлэн баталж, бодлогын үндсэн чиглэлүүдийн нэгийг "Тогтвортой санхүүжилт ба уур амьсгалын өөрчлөлтийн удирдлага" гэж тодорхойлсон. Дэлгэрэнгүйг Тогтвортой хөгжил ба БОНЗ-ын 2024 оны тайлангийн "Тогтвортой байдал, БОНЗ-ын удирдлага" хэсгээс үзнэ үү.
E3.2		Уур амьсгалын эрсдэл ба боломжийн үнэлгээ	Танай компани уур амьсгалын эрсдэл, боломжийн талаарх үнэлгээ хийсэн үү? (сценарийн шинжилгээ, стресс тест гэх мэт)	Тийм	Тийм		ОУ-ын зөвлөх үйлчилгээний үр дүнд бид БОНЗ-ын эрсдэлийн үнэлгээний аргачлалаа төрөлжүүлэн сайжруулах, процессыг түлхүү зээлийн эрсдэлийн удирдлагад нэгтгэх, БОНЗ-ын үнэлгээний шалгуурт уур амьсгалын эрсдэлийн үзүүлэлтүүдийг нэмж тусгах зорилготой ажиллууд төлөвлөгөөний дагуу эхэлсэн хэрэгжих шатандаа үргэлжилж байна.
E3.3		Эдийн засгийн хохирол	Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшиг, үйл явдлын улмаас учирсан эдийн засгийн нийт хохирлын хэмжээ	-	354,517,851	Төгрөг	Сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн цаг агаарын эрс тэс үзэгдлийн давтамж нэмэгдэж, өвөл, хаврын улиралд зудын эрсдэлийг нэмэгдүүлж байна. Үүний үр дүнд 2024 онд малын хоргодол 14.4 хувьд хүрсэн байна. Иймд, банк малчны зээлийг төлөх чадварт ихээхэн сөрөг нөлөө үзүүлнэ гэж үзэж, малчны зээлийн багцын ирээдүйн төлвийг тусад нь авч үзэн, 2024 оны 12-р сарын 31-ний байдлаар тодорхой бүс нутаг болон аймгуудын малчны зээлийн багцын хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тооцоолсон. Дэлгэрэнгүй тооцооллыг ХААН Банкны амжилтлагдсан санхүүгийн тайлангаас үзнэ үү.
E3.4		Уур амьсгалын хөрөнгө оруулалт	Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг дэд бүтэц, дасан зохицол, бүтээгдэхүүн хөгжилд оруулсан нийт хөрөнгө оруулалтын дүн	2,600,000	1,483,808,740	Төгрөг	"Тогтвортой хөгжил ба БОНЗ-ын тайлан 2024" дахь Тогтвортой үйл ажиллагаа хэсгээс дэлгэрэнгүй үзнэ үү.

E3.5		Уур амьсгалын өөрчлөлтөөс урьдчилан сэргийлэх эсвэл дасан зохицох	Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор танай компанийн ашигт ажиллагаа эсвэл бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарт нөлөөлөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, (хэрэв урьдчилан сэргийлэх боломжгүй бол) дасан зохицох чиглэлд хэрэгжүүлэх арга хэмжээ/алхмуудыг тодорхойлсон уу?	Тийм	Тийм		Банкны "Эрсдэлийн удирдлагын ерөнхий бодлого"-д Уур амьсгалын өөрчлөлтөөс үүсэх эрсдэлийн тогтолцоог тусгаж оруулсан. Банкны уур амьсгалын эрсдэлийн дотоод лимитийн үзүүлэлтүүдийг баталж, эрсдэлийн түвшинг улирал бүр хянаж "Ногоон" түвшинд ханган ажилладаг.
E4.1	Ус	Усны хэрэглээ	Ашигласан усны нийт хэмжээ	19,647	29,788	м3/Л	ХААН Банк цамхагийн усны хэрэглээ өмнөх онтой харьцуулахад 52 хувиар өссөн нь оффист ажиллах ажилтны тоо өссөнтэй холбоотой байна
E4.2		Хэмнэсэн ус	Хэмнэлт, үр ашгийг дээшлүүлснээр нийт хэмнэсэн/дахин боловсруулсан усны хэмжээ	-	-	м3/Л	
E4.3		Дахин боловсруулсан ус	Дахин ашигласан болон боловсруулсан усны эзлэх хувь	-	-	%	
E4.4		Хаягдал бохир ус цэвэрлэх	Цэвэрлэсэн нийт хаягдал бохир усны хэмжээ	-	-	м3/Л	
E5.1	Хатуу хог хаягдал	Хог хаягдал	Нийт ялгаруулсан хог хаягдлын хэмжээ	21	114	тонн	2024 онд банкны хэмжээнд нийт 114 тонн хог хаягдлыг ялгаруулсан байна. Тайлбар: 2023 онд зөвхөн Төв банкны хэмжээнд ялгаруулсан хог хаягдлын хэмжээг тайлагнасан бол тайлант онд хэмжилтийн аргачлалыг сайжруулан банкны хэмжээнд нийт ялгаруулсан хог хаягдлын хэмжээг тайлагналаа.
E5.2		Дахин боловсруулсан хатуу хог хаягдал	Хог хаягдлыг дахин боловсруулсан хувь	20	6.4	%	2024 онд банкны хэмжээнд нийт 6.4 тонн хог хаягдлыг дахин боловсруулсан байна. Тайлбар: Тайлант онд хэмжилтийн аргачлалыг сайжруулан банкны хэмжээнд нийт дахин боловсруулсан хог хаягдлын хэмжээг тайлагналаа.
E5.3		Хортой хог хаягдал	Хортой хог хаягдлын нийт хэмжээ (Үүнд цахилгаан хэрэгслийн хог орно)	0.06	0.19	тонн	2024 онд банк хэмжээнд хортой хог хаягдлын хэмжээ 0.19 тонн байна.
E6.1	Биологийн олон янз байдал	Ногоон байгууламж, төлөвлөлт	Байгаль орчны хувьд тогтвортой ашиглаж буй нийтийн эзэмшлийн талбай буюу барьсан ногоон байгууламжийн талбайн нийт талбайд эзлэх хувь	30	30	%	Төв оффисын ногоон байгууламжид 1,600 м ² зүлэгжүүлэлт, 39 ширхэг нарс мод болон 200 м ² жижиг бут тарьсан байна.
E6.2		Зэрлэг ургамал, амьтдыг хамгаалах	Хамгаалсан төрөл зүйлийн тоо	-	-	Төрөл зүйлийн тоо	
E6.3		Биологийн олон янз байдалд сөргөөр нөлөөлж буй үйл ажиллагаа	Тусгай хамгаалалттай газар нутаг, биологийн олон янз байдал, соёлын үнэ цэнэ өндөртэй газар нутгийг эзэмшиж, түрээсэлсэн, удирдаж байгаа эсвэл зэргэлдээх үйл ажиллагааны талбайн нийт талбайд эзлэх хувь	-	-	%	
S1.1	Хүний нөөц	Хүний нөөцийн тогтвортой байдал	Үндсэн ажилтнуудын ажлын байрны сэлгээний хувь (тухайн онд ажлаасаа гарсан ажилтнуудын тоог ажилласан ажилтнуудын дундаж тоонд хуваах)	16.3	14	%	2024 онд үндсэн ажилтнуудын ажлын байрны сэлгээний хувь өмнөх онтой харьцуулахад 2.3 хувиар буурсан байна.
S1.2		Шинээр бий болгосон ажлын байр	Өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн бүтэн цагийн ажлын байрны тоо	-	69	Тоо	2024 онд бүтэн цагийн 69 шинэ ажлын байр нэмэгдсэн байна.
S1.3		Сургалт	Нэг ажилтанд ногдох жилийн дундаж сургалтын цаг	39	12.5	цаг	2024 онд сургалтын нэг ажилтанд ноогдох цагийн хэмжээ 33 цаг 43 минут байна. Тайлбар: Тайлант онд хэмжилтийн аргачлалыг сайжруулан банкны хэмжээнд нэг ажилтанд ногдох жилийн дундаж сургалтын цагийг тайлагналаа.
S2.1	Хөдөлмөрийн аюулгүй	ХАБЭА-н бодлого	ХАБЭА-н бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэгсэн)?	Тийм	Тийм		Дэлгэрэнгүйг Тогтвортой хөгжил ба БОНЗ-ын 2024 оны тайлангийн "ХАБЭА"-н хэсгээс үзнэ үү.
S2.2		Осол аваар	Үйл ажиллагааны явцад гарсан осол аварын хувь	0.3	0		Тайлант онд Банкны үйл ажиллагааны явцад осол гараагүй байна.
S2.3		ХАБЭА-н сургалт	Жилд нэг ажилтанд ногдох дундаж ХАБЭА сургалтын цаг	4 цаг 6 мин	5 цаг 30 мин		

S2.4	байдал, эрүүл ахуй (ХАБЭА)	Эрүүл мэндийн хөтөлбөр	Эрүүл мэндийн үзлэг зэрэг сайн дурын эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдсан ажилчдын тоо, жилээр	8,892	8,963	хүн	Урьдчилан сэргийлэх үзлэгт 985 ажилтан, зөвлөгөөний үзлэгт 87 ажилтан, онцгой бүсэд 114 ажилтан, эмчийн өдөр тутмын үзлэгт 776 ажилтан, сэтгэл зүйн ганцаарчилсан уулзалтанд 198 ажилтан, сэтгэл зүйн бүлгийн сургалтанд 19 газар, нэгж хамрагдсан байна. Мөн эрүүл мэндийн даатгалд 265 ажилтан хамрагдсан бөгөөд сэтгэл зүйн ганцаарчилсан уулзалтад 218 ажилтан, бие заслын үйлчилгээнд давхардсан тоогоор 6,538 ажилтан, толгой хүзүүний барианд 2,782 ажилтан давхардсан тоогоор хамрагдсан байна.
S3.1	Эрх тэгш байдал	Жендэрийн бодлого, журам	Жендэрийн бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм	Тийм		2022 оны 9-р сарын 28-ны өдөр батлагдсан "ХААН Банкны хөдөлмөр эрхлэлтийн эрх тэгш байдлыг хангах тухай бодлого"-д жендэрийн талаар баримтлах бодлогыг тусгасан.
S3.2		Ажлын байрны бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам	Бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм	Тийм		Ажлын байрны дарамт, хүчирхийлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, энэ талаарх гомдлыг хүлээн авч шийдвэрлэх журам 2022 оны 8-р сарын 19-нөөс эхлэн хэрэгжиж байна.
S3.3		Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам	Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм	Тийм		2022 оны 9-р сарын 28-ны өдөр батлагдсан "ХААН Банкны хөдөлмөр эрхлэлтийн эрх тэгш байдлыг хангах тухай бодлого"-д ялгаварлан гадуурхалтын эсрэг баримтлах бодлогыг тусгасан.
S3.4		Ажилтнуудын хүйсийн харьцаа	Нийт үндсэн ажилтнуудын тоонд эрэгтэй, эмэгтэй ажилтны эзлэх хувь	32/68	32/68	%	Нийт ажилтны 32 хувь нь эрэгтэй, 68 хувь нь эмэгтэй ажилтан байна.
S3.5		Удирдах зөвлөлийн хүйсийн харьцаа	Удирдах зөвлөлийн гишүүдийн эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	78/22	78/22	%	ТҮЗ-ийн гишүүдийн 78 хувь нь эрэгтэй, 22 хувь нь эмэгтэй байна.
S3.6		Гүйцэтгэх удирдлагын хүйсийн харьцаа	Гүйцэтгэх удирдлагын түвшний ажилтнуудын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	64/36	41/59	%	Гүйцэтгэх удирдлагын 41 хувь нь эрэгтэй, 59 хувь нь эмэгтэй байна.
S3.7		Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын хүйсийн харьцаа	Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	32/68	34/66	%	Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын 34 хувь нь эрэгтэй, 66 хувь нь эмэгтэй байна.
S3.8		Жендэрт суурилсан цалингийн зөрүү	Эрэгтэй ба эмэгтэй ажилтнуудын дундаж цалингийн харьцаа	46/54	47/53	харьцаа	
S4.1	Хүртээмжтэй байдал	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бодлого, журам	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм	Тийм		"ХААН Банкны хөдөлмөр эрхлэлтийн эрх тэгш байдлыг хангах тухай бодлого"-д олон талт ялгаа байдал, үүн дотроо хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хүндэтгэх, энэ талаар баримтлах бодлогыг тусгасан.
S4.2		Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнууд	Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудын нийт ажилтны тоонд эзлэх хувь	2	2	%	2021 оноос Монголын хараагүйчүүдийн төвийн харьяа хөгжлийн бэрхшээлтэй бариач нарыг ажиллуулж, ажилтнуудад барианы үйлчилгээ үзүүлдэг болсон ба 2022 оноос худалдан авах гэрээгээр тус үйлчилгээг авч гэрээний төрөл өөрчлөгдсөн.
S4.3		Оффисын хүртээмж	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлаар шийдсэн оффис, байгууламжтай юу?	Тийм	Тийм		Монгол Улсын Барилгын тухай хууль, Барилгын норм ба дүрмийн дагуу банкны эзэмшлийн бүх барилгууд налуу замтай. Төв оффисын хувьд ОУ-ын оффисын А зэрэглэлийг хангасан стандарттай учир налуу зам, тэргэнцэртэй иргэн орж, гарахад зориулсан хаалга, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан тусдаа ариун цэврийн өрөө гэх мэт ерөнхий шаардлагауд бүгд хангагдсан. 2024 онд Төв оффис нь Дэлхийн ногоон барилгын зөвлөлийн "LEED" үнэлгээгээр "GOLD" ангилалд шалгарсан.
S4.4		Торгууль	Байгаль орчны зөвшөөрөл, стандарт, дүрэм журмыг дагаж мөрдөөгүйгээс гарсан зөрчлийн тоо	0	0	Төгрөг	Зөрчил байхгүй.
S5.1		Оролцогч талуудын оролцооны засаглал	Оролцогч талуудтай хамтарч ажиллах талаар тусгайлан бодлого байгаа юу?	Үгүй	Тийм		"ХААН Банк ХК"-ийн "Хөрөнгө оруулагчидтай харилцах бодлого"-ыг 2024 онд баталж, ТҮЗ болон нийт ажилтнууд хэрэгжүүлэн ажиллаж байна. Тус бодлогын зорилго нь хөрөнгө оруулагчид болон боломжит хөрөнгө оруулагчдыг хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр хангах, бусад оролцогчдод банк болон түүний зорилгын талаар тэнцвэртэй ойлголтыг хүргэхэд банкныг шударга, үнэн зөвөөр төлөөлөх явдал юм.
S5.2		Нийгмийн нөлөөллийн үнэлгээ, газар чөлөөлөлтийн бодлого журам	Танай компани нийгэмд нөлөөлөх байдлын бодлого, журамтай юу? (Үүнд газар чөлөөлөлт багтана)	Үгүй	Үгүй		

S5.3	Нийгмийн хариуцлага ба ил тод байдал	Санал гомдлыг шийдвэрлэх бодлого/журам	Гомдол маргааныг шийдвэрлэх бодлого, механизм бий юу?	Тийм	Тийм		ХААН Банк нь Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015, Чанарын менежмент-Байгууллагад гомдол шийдвэрлэх удирдамж ISO 10002:2018 олон улсын стандартыг нэвтрүүлсэн. Ингэснээр банкны хэмжээнд үйл ажиллагаандаа нэгдсэн цогц менежментийн тогтолцоог хэрэгжүүлж харилцагчид хүргэх бүтээгдэхүүн үйлчилгээний чанарыг тогтмол сайжруулж, олон улсын түвшинд нийцүүлэн ажиллах юм. Бид харилцагчийн гомдлыг шийдвэрлэхдээ "Харилцагчийн гомдол хүлээн авах, бүртгэх, шийдвэрлэх үйл ажиллагааны журам"-ыг мөрдлөг болгон ажилладаг. Гомдол бүртгэх, хүлээн авах, шийдвэрлэх үйл ажиллагааны процессын талаар дэлгэрэнгүй мэдээллийг ЭНД дарж үзнэ үү. https://www.khanbank.com/personal/news/servicePolicy/
S5.4		Олон нийтэд ил тод мэдээлэх	Танай компанийн үйл ажиллагаа нөлөөлж буй иргэдэд мэдээлэл өгөх, санал хүсэлт авч, гомдол шийдвэрлэх тогтолцоо бий юу?	Тийм	Тийм		Бид "Харилцагчийн гомдол хүлээн авах, бүртгэх, шийдвэрлэх үйл ажиллагааны журам"-ын дагуу харилцагчдаас гомдлыг дараах сувгуудаар хүлээн авч шийдвэрлэдэг. 1. Салбар, тооцооны төв 2. Үйлчилгээний нэгдсэн төв 18001917 3. Khanbank.com вэб сайт 4. Khanbank аппликэйшн 5. Khanbank сошиал сувгууд 6. Өргөдөл, маягтаар.
S5.5		Ажилчид/олон нийтийн санал гомдол	Ажилчид болон олон нийтээс ирсэн санал гомдлыг шийдэрлэсэн хувь	92	93.63	%	2024 онд нийт санал, гомдлын 93.63 хувийг шийдвэрлэсэн байна.
S5.6		Нийгмийн хариуцлагын үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө оруулалт	Нийгмийн хариуцлагын арга хэмжээ, хөтөлбөрт зарцуулсан хөрөнгө оруулалтын нийт орлогод эзлэх хувь	0.3	0.64	%	ХААН Банк байгуулагдсан цагаасаа хойш компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсээр байна. Дэлгэрэнгүйг Тогтвортой хөгжил ба БОНЗ-ын 2024 оны тайлангийн "Тогтвортой нийгмийн хөрөнгө оруулалт" хэсгээс үзнэ үү.
S6.1	Тогтвортой өртгийн сүлжээний менежмент	Худалдан авалтын бодлого, журам	Танай компанид дотоодын худалдан авалт болон тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн эрсдэл боломжыг хангасан худалдан авалтын бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм	Тийм		Дэлгэрэнгүйг Тогтвортой хөгжил ба БОНЗ-ын 2024 оны тайлан дахь "Нийлүүлэлтийн сүлжээний удирдлага" хэсгээс үзнэ үү.
S6.2		Дотоодын худалдан авалт	Дотоодын ханган нийлүүлэгчдээс авсан худалдан авалтын хувь	86	86	%	Дэлгэрэнгүйг Тогтвортой хөгжил ба БОНЗ-ын 2024 оны тайлан дахь "Нийлүүлэлтийн сүлжээний удирдлага" хэсгээс үзнэ үү.
S6.3		Тогтвортой, ногоон худалдан авалт	Нийт ханган нийлүүлэгчдийн тоонд тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн шалгуураар сонгогдсон ханган нийлүүлэгчдийн хувь	15	-	%	Худалдан авалтын журмын 4.4 заалт нь тогтвортой хөгжил ба нийгмийн хариуцлагын зарчмуудыг тусгасан байдаг. Түүнчлэн Худалдан авах ажиллагааны журмын эрсдэлийн тайланд бид ханган нийлүүлэгчдийг дээрх зарчмууд, тогтвортой хөгжлийн бодлого, нийгмийн хариуцлагын талаар сурталчлах, гуравдагч этгээдийн асуулга авах замаар мэдээллээр хангах, хүлээн авах арга хэмжээ авдаг.
G1.1	Авилгал болон ёс зүй	Авилга, хээл хахуулийн эсрэг бодлого журам	Авилгын эсрэг эсвэл Ёс зүйн бодлого, журам бий юу?	Тийм	Тийм		Дэлгэрэнгүй мэдээллийг ЭНД дарж үзнэ үү.
G2.1	Компанийн засаглал	Удирдах зөвлөлийн хараат бус байдал	Удирдах зөвлөлд хараат бус гишүүдийн суудлын хувь	33	33	%	Дэлгэрэнгүй мэдээллийг ЭНД дарж үзнэ үү.
G2.2		Цөөнх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх	Цөөнх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах дүрэм, журам бий юу?	Тийм	Тийм		Дэлгэрэнгүй мэдээллийг ЭНД дарж үзнэ үү.
G2.3		Компанийн засаглалын бодлого, журам	Компанийн засаглалын бодлого, журам бий юу?	Тийм	Тийм		Дэлгэрэнгүй мэдээллийг ЭНД дарж үзнэ үү.

G3.1	Комплайнс	Комплайнсын бодлого	Комплайнсын бодлого, журам бий юу?	Тийм	Тийм	ХААН Банк нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт, зарчмуудыг дотоод бодлого, журмаа тодорхойлон тусгасан бөгөөд үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж байна. Бодлого, журамд жил бүр хяналт тавьж, хууль тогтоомж, зохицуулагч байгууллагын дүрэм, журам, удирдамж шинэчлэгдэхэд нийцүүлэн тогтмол шинэчлэл хийх арга хэмжээ авдаг. Дэлгэрэнгүй мэдээллийг ХААН Банкны вэбсайтаас үзнэ үү.	
G3.2		Комплайнсын хөтөлбөр	Комплайнсын хөтөлбөр, журам (ажилчдын сургалт, аудит, хяналтын систем, зөрчлийн талаар мэдээлэх, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх удирдамж, хориг гэх мэт) бий юу?	Тийм	Тийм	Банкны хэмжээнд дагаж мөрдөх Комплайнсын дотоод хяналтын хөтөлбөрийг боловсруулсан бөгөөд 2023-2025 оны хөтөлбөрийг Банкны Гүйцэтгэх удирдлага баталсан. Комплайнсын хөтөлбөрийн дагуу МУТСТ, Харилцагч таньж мэдэх, хориг арга хэмжээний хяналтын тогтолцоог тогтмол сайжруулах, үр дүнтэй тогтолцоог бий болгох зорилгоор бодлого, журманд өөрчлөлт оруулахын зэрэгцээ, дижитал шилжилт, үйл ажиллагааг автоматжуулах, арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг банкны хэмжээнд хангуулан ажиллаж байна. Хөтөлбөрийн хэрэгжилтийг Банкны ТУЗ, Гүйцэтгэх удирдлага болон Монголбанканд тогтмол тайлагнаж ажиллаж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг ХААН Банкны вэбсайтаас үзнэ үү.	
Нэмэлт салбарын шалгуур үзүүлэлтүүд (Танай компанид хамаарах салбарын асуултуудыг бөглөнө үү)							
FS1	Санхүүгийн үйлчилгээ	Санхүүгийн хүртээмж	Санхүүгийн мэдлэг дээшлүүлэх болон санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах санаачилга, арга хэмжээнд оролцсон хүмүүсийн тоо, жилээр	75,440	75,600	хүн	Тайлант онд Монгол орон даяар тархсан 540 гаруй салбар нэгжээрээ дамжуулан нийт 75,600 гаруй иргэд, хүүхэд залууст санхүүгийн боловсрол олгох сургалт, мэдээлэл хүргэн ажилласан.
FS2		БОНЗ-ын эрсдэлийн менежмент	БОНЗ-ын эрсдэлийн шалгуур болон хориотой үйл ажиллагааны жагсаалтаар үнэлсэн гүйлгээний хувь	9.5	52.02	%	2024 онд нийт 3.5 их наяд төгрөгийн 809 зээлийн хүсэлтэд байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэлийн үнэлгээг хийсэн. Энэ нь нийт зээлийн багцын үлдэгдлийн 52.02 хувийг эзэлж байна.
FS3		Тогтвортой санхүүжилт	Нийт зээлийн багцад эзлэх ногоон/ТХЗ таксономийн ангилалд нийцсэн ногоон/тогтвортой зээлийн эзлэх хувь	3.92	6	%	Тайлант хугацаанд ХААН Банк 712 тэрбум төгрөгийн ногоон зээлийн багцыг бүрдүүлсэн ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад зээлийн багц эзлэх хувь 2 хувийн өсөлттэй байна.